

БАТЛАВ:



Д.ЦОЛМОНБААТАР
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ
ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР

“ГОВЬ-УС-ХӨГЖИЛ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Нэг. Хурлын зорилго

Говийн бүсийн усны нөөц, ус ашиглалт, усны менежмент, ус ба бүс нутгийн тогтвортой хөгжлийн харилцан хамаарлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэлэлцэн, бодлого, судалгаа, технологи, инновац болон олон талт түншлэлийн шийдлийг нэгтгэн боловсруулахад хурлын зорилго оршино.

Хоёр. Хурлын зорилтууд

- ✓ Говийн бүсийн усны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох;
- ✓ Усны нөөцийн хамгаалалт, зохистой ашиглалт, нөхөн сэргээлтийн шийдлүүдийг хэлэлцэх;
- ✓ Уул уурхай, хотжилт, хүн амын өсөлт, бэлчээрийн даац, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой усны сорилтуудыг авч үзэх;
- ✓ Төр, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- ✓ Орон нутгийн хөгжлийн шийдвэр гаргалтад шинжлэх ухааны оролцоог нэмэгдүүлэх;
- ✓ Хурлын үр дүнд боловсруулсан зөвлөмж, саналуудыг холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх;

Гурав. Ерөнхий зохион байгуулагч

- Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн ажлын алба
- Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар
- Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль

Дөрөв. Зохион байгуулагч байгууллага

- Өмнөговь аймгийн Байгаль орчны газар
- ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль

Тав. Оролцогч байгууллагууд

- Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль
- Монгол Улсын Их Сургууль
- Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
- Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
- Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи

- Үндэсний Шинжлэх Ухаан Технологийн Сан
- Усны газар

Зургаа. Хамрах хүрээ

- Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн багш, судлаачид;
- Ус, байгаль орчин, уул уурхай, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, боловсролын салбарын судлаачид;
- Магистр, доктор, залуу судлаачид;

Долоо. Хугацаа

“Говь-ус-хөгжил” сэдэвт Эрдэм шинжилгээний хурал 2026 оны 05 дугаар сарын 25-ний өдөр цахим, танхимаар зохион байгуулагдана.

Найм. Өгүүлэлд тавих шаардлага

ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих загварын дагуу бичигдсэн байх, загварыг дараах холбоосоор орж авна уу. <https://research.must.edu.mn/news/207>
Өгүүлэл хүлээн авах и-мэйл хаяг: research@must.edu.mn
Өгүүлэлтэй холбоотойгоор холбогдох утасны дугаар: 99861112

Ес. Материал хүлээн авах болон шалгаруулалтын хугацаа

- Өгүүлэл хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 05 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл
- Бүтээлийн хуулбарлалт шалгах болон Редакцын зөвлөлийн хяналт:
2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл
- Шаардлага хангасан өгүүллийн талаар зохиогчдод мэдэгдэх:
2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр
- Шалгарсан өгүүллийг илтгэл хэлбэрээр хэлэлцэх хурал:
2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр

Арав. Шилдэг илтгэлд олгох грант

- Шилдэг илтгэл 5,000,000 төгрөг
- Дэд байр 3,000,000 төгрөг
- Гурав дугаар байр 2 000 000 төгрөг

Арван нэг. Бүтээлийг нийтэд түгээн дэлгэрүүлэх

Хуралд хэлэлцүүлсэн Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн эмхэтгэлийг ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн албанаас эрхлэн гаргаж олны хүртээл болгох

Зохион байгуулахтай холбоотойгоор холбогдох утасны дугаар: 99051416